

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

ОЛОН НИЙТИЙН РАДИОГИЙН НЭВТРҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨРТ
ХИЙСЭН АЖИГЛАЛТ ДҮГНЭЛТ

Ц.Оюунтунгалаг*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үг: радиогийн хөтөлбөр төлөвлөлт; олон нийтийн радиогийн хөтөлбөрийн онцлог, өөрчлөлт; олон нийтийн эрх ашиг, сонирхол, эрэлт хэрэгцээ

Радиогийн хөтөлбөр төлөвлөлт бол нэвтрүүлгүүдийн цогц иж бүрдэл юм. Программ нь тухайн радио сувгийн нэвтрүүлгүүдийн бодлогоор тодорхойлогдохоос гадна сонсогчид /хэрэглэгчдийн/ эрэлт хэрэгцээнд тулгуурлана.

Монголын үндэсний радио “Олон нийтийн” гэсэн статустай болсноос хойш арав гаруй жил өнгөрч байна. Төрийн мэдлийн мэдээллийн хэрэгслээс олон нийтийн эрх ашигт үйлчилдэг болон өөрчлөгдөж, гагцхүү хуулиар байгуулагдаж, үйл ажиллагааг нь хуулийн хүрээнд, олон нийтийн радиогийн зарчимд үндэслэн ажиллах болсон нь Монголд Олон нийтийн радио үүсэн хөгжих таатай орчныг бүрдүүлсэн юм. Ийнхүү олон нийтийн радио Монголд байгуулагдсанаар хэвлэлийн эрх чөлөөг бататгах, Монголын сэтгүүл зүйн хөгжилд нэгэн шинэ хуудас нээгдэж, хэвлэл мэдээллийн салбарын

төдийгүй Монголын ардчиллын нэгэн салшгүй хэсэг болон хөгжиж байна. Өнгөрсөн хугацаанд Олон нийтийн радио болон өөрчлөгдснөөр шинэ тутам асуудал сорилт бэрхшээлүүдтэй тулгарч байна.

Программ (хөтөлбөр) бол нэг зэрэг тухайн сувгийн баримталж буй бодлогыгилэрхийлэх бөгөөд тухайн радиогийн үйл явдалд харьцах харьцаа, түүнчлэн мэдээллийг хүлээн авагч-сонсогчдынэрэлт, хүлээлт, сонсогчдын сонирхол юм.¹

Олон нийтийн радиогийн хувьд эфирийн хөтөлбөр болон төлөвлөлт онцгой үүрэгтэй. Олон нийтийн радиогийн хөтөлбөрийн бодлого нь бусад төрлийн радиогоос хөтөлбөрийн бодлого нь хуульчлагдсан, олон нийтийн эрх ашигт үйлчлэх үүргийг хуулиар хүлээсэн байдаг онцлогтойгоороо ялгардаг. 2005 онд батлагдсан “Олон нийтийн радио телевизийн тухай”² хуульд олон нийтийн радио телевизийн хөтөлбөрийн талаар 8 зүйл бүхий тусгай бүлгээр зохицуулсан байна. Тус хуульд хөтөлбөрийн бодлого, хөтөлбөрт тавигдах тусгай шаардлага, нэвтрүүлгийн баримтыг хадгалах, нэвтрүү-

лэгт залруулга тайлбар хийх зэрэг олон чухал харилцааг хуульчилж өгсөн байна. Олон нийтийн радио нь арилжааны хувийн радиогийн гол шинж болох шуугиан дэгдээсэн, цэнгээнт, хөгжөөнт нэвтрүүлэг рүү туйлшрах хандлагаас зайлсхийхийн тулд нэвтрүүлгийн бодлогод тэнцвэрт байдлыг хадгалах зарчим буюу хүлээн авагчид мэдээллийн, улс төр, нийтлэлийн, сургалтын, соёлын болон хөгжөөнт зэрэг янз бүрийн чиглэлийн чанартай нэвтрүүлэг сонсох боломжоор хангагдсан байх ёстой гэсэн зарчмыг баримталдаг.³ Энэхүү хөтөлбөр нь сонсогчид хүрч буй нэвтрүүлгийн дараалал хэдий боловч нэвтрүүлгийн төрөл, түүний хөтөлбөр дэх харьцаа, олон нийтийн радиогийн нэвтрүүлгийн бодлогод баримтлах зарчим, түүний хэрэгжилт, хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн бие-лүүлж байгаа, мэдээлэл хүлээн авагч-олон нийтийн эрх ашиг, сонирхолд хэрхэн нийцүүлсэн зэргийг харах, задлан шинжлэх боломжийг олгож байдаг. Хөтөлбөрийн бүтэц нь Олон нийтийн хэмээх статусаа хэрхэн хадгалж байгааг нотлон харуулах нүүр царай болох юм. Олон нийтийн радиогийн хөтөлбөр төлөвлөлтөөс олон нийтийн эрх ашигт хэрхэн үйлчилж байгааг шинжин харах боломжтой байдаг. Монголын радиогийн нэгдүгээрсуваг өдөр бүр 06:00-23:00 цагийн хооронд нийт 17 цагийн хөтөлбөрийг өдөр бүр сонсогчиддоо хүргэж байна. Энэ нь долоо хоногоор авч үзвэл 119 цагийн хөтөлбөрийг олон нийтэд хүргэж байгаа гэсэн үг юм.

2005 оны тавдугаар сараас хууль амьдрал дээр хэрэгжиж, төр засгийн мэдлээс гарч, олон нийтийн статустай болсноос хойш бүтэц зохион байгуулалтаас гадна хөтөлбөрөө

шинэчлэх ажлыг эхлүүлсэн. МҮОНР-ийн хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсэг байгуулж, өмнөх хөтөлбөртөө дүн шинжилгээ хийж, уран бүтээлчдээсээ шинэ нэвтрүүлгийн санал авах ажлыг зохион байгуулсан байна. Хөтөлбөр шинэчлэлтээр боловсрол танин мэдэхүйн чиглэлийн нийтлэл нэвтрүүлгийн хувь хэмжээ 2 дахин, түүх урлаг соёлын нэвтрүүлэг 2 хувиар, дуу хөгжим, цэнгээнт нэвтрүүлэг 3 хувиар өссөн байна. Арилжааны реклам байхгүй болж, нийгмийн зар сурталчилгаанд зориулсан зар мэдээний цаг 2 хувь болон нэг дахин буурсан байна.⁴

Арилжааны зар сурталчилгааг хориглож, нийгмийн чанартай зар сурталчилгаа нэвтрүүлэх болсон ч төлбөрт буюу гадны байгууллагуудын гэрээ байгуулан мөнгө төлдөг нэвтрүүлгүүд нэвтрүүлгийн сүлжээнд тавигдаж байгааг ч хойшид анхааран цэгцлэх нь зүйтэй. Төлбөрт нэвтрүүлэг нь олон нийтийн радиогийн баримтлах зарчимд харшилж байгаа эсэх, редакцийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлж байгаа эсэх зэрэгт үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай.

Олон нийтийн болсноос хойш байгууллагын баримтлах зарчим, эрхэм зорилго өөрчлөгдсөнтэй холбоотойгоор, мөн хуулийн заалтанд хөтөлбөрийн бодлогоо уялдуулах алхмуудыг хийж эхэлсэн. Энэхүү эхлэл нь цаашид Олон нийтийн радиогийн хөтөлбөрийн бодлого, бүтэц улам гүнзгийрэн хөгжих үндэс болсон юм. Олон нийтийн радиогийн зарим болон хуульд нийцүүлсэн өөрчлөлтийг тусгасан шинэчилсэн хөтөлбөрийг 2006 оны тавдугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Нэвтрүүлгийн сүлжээнд хийсэн өөрчлөлтүүд нь дараах байдлаар илэрч байна.

1. Нэвтрүүлгийн хөтөлбөрөө шинэ нэвтрүүлгээр баяжуулсан. Үүнтэй уялдуулан нийт нэвтрүүлгийн тоо нэмэгдсэн. “Монгол хүүхэд”, “Цэцэн үг цээжинд”, “Радио цэцэрлэг”, “Дуун таавар”, нэвтрүүлгийг шинээр нээжээ. Нийгмийн тодорхой зорилтот бүлэгт зориулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Хөшгөө татсан цонх”, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн “Алхам алхмаар” зэрэг нэвтрүүлэг нээсэн зэрэг нь шинэлэг алхам болж байв.
2. Зарим нэвтрүүлгийн агуулгад эрс өөрчлөлт хийсэн. Тухайлбал, “Найм арван нэг” хөтөлбөр нь төр засгийн мэдээлэл болон улс төрийн мэдээллийг дагнаж мэдээлдэг байсан бол өөрчлөгдөж, нийгэм, эдийн засаг, улс төрийн мэдээллийн тоймчийн хөтөлбөр болон өөрчлөгдсөн. Засгийн газар, УИХ, Шадар сайдын ажлын 7 хоногийн ажлын тойм нэвтрүүлдэг байсныг болиулах зэргээр агуулгын өөрчлөлт хийснийг дурдах нь зүйтэй.
3. “Реалити шоу” хөтөлбөрийг нээж, цэнгээнт нэвтрүүлгийн тоо хэмжээ нэмэгдсэн нь радиогийн хөтөлбөрт урьд өмнө орж байгаагүй шинэчлэлийн нэг байв.
4. Эргэх холбоо–сонсогчдын оролцоог нэмэгдүүлэх оролдлогуудыг хийж эхэлсэн. “Уулзах цэг” (2012) нэвтрүүлгийг нээж, долоо хоног бүрийн ням гарагт 50 минутын хугацаатайгаар сонсогчидтойгоо радиогийн сэтгүүлч уран бүтээлчид шууд холбогдож, тухайн 7 хоногийнхоо уран бүтээлийн талаар чин сэтгэлийн талархал, ажил хэрэгч шүүмжлэлийг ч бас хүлээн авч, сонсогчдынхоо санал бодлыг сонсож ирсэн. Мөн нэвтрүүлэгт оролцож буй сон-

согчдынхоо мэдээллийг боловсруулж, анализ дүгнэлт хийх ажлыг 2007 оноос хийж ирсэн нь сонсогчдын эргэх холбоог сайжруулах ажилд анхаарч эхэлсэн. Сонсогчидтойгоо холбогдох 1986 тусгай дугаар ажиллуулж эхэлсэн боловч үр дүнтэй ажиллаж чадалгүй хаагдсан байна.

Монголын үндэсний радио нь олон нийтийн сонирхол, эрх ашигт нийцсэн хөтөлбөртэй болохын тулд жил бүр хөтөлбөрөө шинэчлэн сайжруулсаар иржээ. Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн хөтөлбөр шинэчлэлийн хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлтүүд нь Шведийн радиогийн мэргэжилтнүүдийн туршлага, заавар зөвлөмж, хэрэгжүүлсэн төслийн үлдэцтэй нааштай үр дүн байсныг бас тодотгон тэмдэглэх нь зүйтэй. Ялангуяа “Хурд” агентлагт хийгдсэн шинэчлэлүүдийг Шведийн радиогийн “Экот” мэдээллийн агентлагийн жишгээр хийсэн нь гадаадын Олон нийтийн радиогийн жишигт хүрч ажиллах үндэс суурь болсон юм. Тухайн өдрийн гол үйл явдлыг тусгаж, багийн хөдөлмөрөөр ажлын өдөр бүр 30 минутын хугацаатайгаар “Тусгал” мэдээллийн шууд хөтөлбөрийг бэлтгэн хүргэх болсон нь ч Монголын үндэсний олон нийтийн радиогийн хувьд шинэ зүйл байв. “Тусгал” мэдээллийн шууд хөтөлбөрийг продюсер, хөтлөгч редактор, сурвалжлагч нарын оролцоотойгоор багийн хөдөлмөрөөр хийж эхэлснээрээ онцлог байсан. Энэхүү мэдээллийн шууд хөтөлбөртэй холбоотойгоор нэвтрүүлгийн продюсер гэсэн ойлголт анх гарч ирсэн. Энэ туршлага дээр үндэслэж шууд нэвтрүүлэг дээр ажиллах продюсер гэсэн орон тоо бий болсон байна. “Тусгал” шууд мэдээллийн хөтөлбөр нь 2010 оны тавдугаар

сарын нэгний өдөр анхны дугаараа цацсан бөгөөд 2017 оны аравдугаар сард хаагдсан. Мэдээллийн брэнд нэвтрүүлгээ ийнхүү хаасан нь оновчтой зүйл биш төдийгүй ажиллах хүч болон зөвхөн дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр ийм шийдвэр гаргасан нь оновчтой биш.

Мөн 2011 онд “Эрэн сурвалжлах баг”-тай болж, “Баримт” эрэн сурвалжлах нэвтрүүлгийг бэлтгэж эхэлсэн төдийгүй сэтгүүл зүйн адармаатай энэ төрөл зүйлд Монголын үндэсний олон нийтийн радиогийн үүрэг оролцоо нэмэгдсэнийг тэмдэглэх нь зүйтэй. МҮОНР-гийн эрэн сурвалжих багийн бүтээлүүд “Балдоржийн шагнал”-д өрсөлдөж, байр эзэлж ирсэн нь хөдөлмөрийнх нь үр дүнг илтгэнэ. Мөн “Цэнгэг” өглөөний хөтөлбөртэй болсон нь ч Барууны радиогийн жишиг хөтөлбөрүүдэд дүйцэх тун чухал алхмууд байв.

Сүүлийн жилүүдэд хийсэн сүлжээний шинэтгэл дундаас 2015 оны шинэчлэлтийг онцлох нь зүйтэй. Даваа, мягмар, лхагва, пүрэв, баасангарагт 12-18 цагийнхооронд “Тэнхлэг” шуудхөтөлбөрийнболгосноор Монголынрадиогийн I сувгийн өдрийн эфирийн 40 хувийг шууд дамжуулдаг болсон байна. Энэ нь сүүлийн 25 жилд хийсэн хамгийн томоохон өөрчлөлт юм. Радио сэтгүүл зүйн хэтийн төлөв, зохиогчийн, хөтөлгөчийн чиглэлд хөгжиж буй энэ цагт продюсер, хөтөлгөч бүхий шууд нэвтрүүлэг, барууны сэтгүүл зүйн стандартыг нутагшуулахад энэ өөрчлөлтийн үндсэн зорилгоор оршиж

байна. “Тэнхлэг” хөтөлбөр ажлын өдрүүдэд 12-18 цагийнхооронд 6 цагийнхугацаатайшуудбэлтгэндамжуулдагМонголынрадиогийнбрэндболсон, үнэцэнэбүхийконтентюм. Гэрбүл, хүнийхөгжил, ёсзүй, хүүхэдзалуусынхөгжил, манлайлал, төлөвшил, нийгмийнидэвхтэйоролцоо, эрүүлмэнд, эрүүлхүн, амьдралынзөвхэвшил, нийгмийнхаламж, хамгаалал, үйлдвэрлэл, хэлсоёл, урлаг, танинмэдэхүй, шашиншүтлэг, нийгмийнүнэтзүйлс, улстөр, эдийнзасаг, хуульэрхзүйнчиглэлийгбагцсэдэвболго

жпродюсерийнудир длагадорбагболон бэлтгэнявуулжбайн а.

МонголынРадиогийнхөтөл-бөрийнбүтцийн 44% ньшууднэвтрүүлэг, 56% ньбичлэгийннэвтрүүлэгэээлжбайна⁵ гэж цахим хуудасныхаа танилцуулгад дурдсан байна.

Эндээс

харахад Монголын үндэсний олон нийтийн радиогийн хөтөлбөрт шууд нэвтрүүлгийн эзлэх хувь хэмжээ нэмэгдсэнээр мэдээллийн багтаамж тэлэх, шуурхай чанар сайжрах, сонсогчийн оролцоо нэмэгдэх, эргэх холбоо сайжрах зэрэг эерэг өөрчлөлт гарч байгааг тодотгох нь зүйтэй.

Монголын Үндэсний Олон нийтийн радиогийн сүүлийн 12 жилийн хугацаанд хийсэн хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлийг тоймлон авч үзээд дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна.

«

2011 онд “Эрэн сурвалжлах баг”-тай болж, “Баримт” эрэн сурвалжлах нэвтрүүлгийг бэлтгэж эхэлсэн төдийгүй сэтгүүл зүйн адармаатай энэ төрөл зүйлд Монголын үндэсний олон нийтийн радиогийн үүрэг оролцоо нэмэгдсэнийг тэмдэглэх нь зүйтэй.

»

- ОНРТВ-ийн тухай хуульд заасан хөтөлбөрийн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс хөтөлбөрийн бодлогоо хуулийн шаардлагад уялдуулах алхмууд хийгдсэн.
- Хөтөлбөрийн шинэчлэлд хоёр ч удаа нийт уран бүтээлчдээсээ санал авч, цөөнгүй нэвтрүүлгийг сүлжээндээ шинээр нэвтрүүлж, 2015 онд нэвтрүүлгийн аттестатчлал явуулснаар цөөнгүй нэвтрүүлгийг сүлжээнээсээ хасчээ. Гэхдээ нэвтрүүлгийн сүлжээнд шинэ нэвтрүүлэг бий болгох, эсвэл хуучин нэвтрүүлгээ хасахдаа сонсогчдын эрэлт хэрэгцээ, тэдний саналд үндэслэдэг байдал харагдахгүй байгаа нь учир дутагдалтай байна.
- МҮОНР нь хөтөлбөртөө хийсэн шинэчлэлийн хүрээнд боловсрол, өв соёл, зан заншил, цэнгээнт нэвтрүүлгийн тоо өссөн дүн харагдаж байна. Гэвч үндэсний цөөнхөд зориулсан нэвтрүүлэг өнөөдрийг хүртэл байхгүй байна.
- Өглөөний хөтөлбөр, мэдээллийн шууд хөтөлбөр, эрэн сурвалжлах багтай болсон зэрэг нь Барууны стандартын Олон нийтийн радиогийн хөтөлбөртэй жишиж болохуйц хэмжээнд хүрчээ.
- МҮОНР-гийн сүлжээнд орж буй өөрчлөлтийн талаар тодорхой албан бичиг баримтууд үйлдэгддэггүй, шийдвэр аман хэлбэрээр гарч, сүлжээ өөрчлөгддөг нь хийсэн өөрчлөлтөө эргэн харах, эсвэл уг асуудлыг судалгааны эргэлтэнд оруулахад хүндрэл учирч байна.

Монголын үндэсний радио нь Олон нийтийн радио болж төлөвших 12 жилийн хугацаанд багагүй туршлага хуримтлуулж, чамгүй амжилт олсон байна. Цаашид хөтөлбөрийн

шинэчлэлийн асуудлыг орхигдуулалгүй авч явж, олон нийт-сонсогчдынхоо эрэлт хэрэгцээг судлах, сонсогчдын саналыг үндэслэн хөтөлбөртөө өөрчлөлт хийх зэрэг алхмыг хийх нь зүйтэй. Зөвхөн дотооддоо уг асуудлыг анхаарч ажиллахаас гадна олно нийтийн сонирхол, тэдний саналыг үндэслэх арга механизмыг боловсронгуй болгох хэрэгтэй. Мөн хөтөлбөрийн шинэчлэлийн асуудлыг дараагийн түвшинд гаргаж, контентийн агуулга, чанарын асуудалд дүн шинжилгээ хийдэг болох, программ төлөвлөлтийн хувьд шинэ тактик, стратеги боловсруулах шаардлагатай.

Ишлэл

- ¹Смирнов.В.В. Жанры радиожурналистики. Москва., 2002. Стр.10
- ²“Олон нийтийн радио телевизийн тухай хууль. 2005. 8-р зүйл
- ³Баярсайхан.Б. Олон нийтийн радиогийн хөтөлбөрийн бодлого, түүний онцлог. Магистрын зэрэг горилсон бүтээл. 2010. 11-р тал
- ⁴Баярсайхан.Б. Олон нийтийн радиогийн хөтөлбөрийн бодлого, түүний онцлог. Магистрын зэрэг горилсон бүтээл. 2010. 28-р тал
- ⁵www.mnb.mn

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Смирнов.В.В. Жанры радиожурналистики. Москва., 2002.
2. Eric G.Norberg. Radio programming tactics and strategy. Boston., 1996
3. Монголын радио түүхэн замналын товч хуанли. УБ., 1994.
4. Баярсайхан.Б. Олон нийтийн радиогийн хөтөлбөрийн бодлого, түүний онцлог. Магистрын зэрэг горилсон бүтээл. 2010.
5. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль
6. МҮОНРТВ-ийн 2006- 2016 онуудын үйл ажиллагааны тайлан

7. www.mnb.mn

Summary

It has been ten years since Mongolian National Radio changed its status into "Public". An urgent need for changing its programs has emerged because of the status changing. There has been a need for a change of broadcasting programming according to public interests. In the present article, we focused on the program changes

in accordance with the public interests and principles of public broadcasting. Although numerous changes, which are worth to be considered as the international public broadcast programming, further domestic broadcast programming is required to be revised in compliance with public interests and their proposals. Previous and current program situations of Mongolian National Public Radio are mainly discussed in the article.